

Япон хүний овог нэрийн тухайд

Ц.Онон* (МУИС)

Япон хүний овгийн нэрийн түүхээс үзвэл, тэд эрт үедээ овгийг эзэн хаанаас хүртдэг байжээ. Ингэснээр эзэн хааныг хамгийн дээд эрхэм хүн гэж хүлээн зөвшөөрч, үнэнч зүтгэхээ тангараглаж байгаагийн гэрч юм. Ийм учраас эзэн хааны гэр бүлд овог гэж байдаггүй.

Эзэн хааны албат л бол түүнд овгийн нэр гэж байх ёстой бөгөөд овгийн нэрийг хүртээхэд тогтсон ямар нэг ёс журам байгаагүй бололтой. Түүхэнд нэрээ үлдээсэн нөлөө бүхий дөрвөн их овог гэгдэх 源氏 Genji, 平氏 Heishi, 藤氏 Fujiwara, 橘 Tachibana (товчлон 源平藤橘 Genpeitoukitsu гэж бичдэг) овгийн нэр ч тэр ямар нэгэн утга учир агуулдаггүй гэнэ.

Овгийн нэр нь эзэн хаанаас хүртдэг зүйл учраас мэдээж буцааж авах, булаалгах, хүчингүй болгох, солих зэрэг үйлдэл ч гардаг байжээ. Ийнхүү хувирч өөрчлөгдөн явсаар, Нарагийн үе гэхэд бүх хүн овогтой болсон бөгөөд олон зуун овог (百姓 Hyakushou-олон зуун тооны овог гэсэн утгатай байснаа одоо тариачин гэсэн утгатай) гэдэг үг энэ үед гарчээ.

Харин цэргийнхэн засгийн эрхэнд гарснаас үүдэн хаяг, оршин суугаа газрын нэр нь овогт тооцогдох болжээ. Өөрөөр хэлбэл өөрөө болон өвөг дээдэс нь амь өрсөн байж нээж илрүүлэн олж авсан газрын нэрийг гэр бүлийн овгоо болгон түүгээрээ бахархах болсон байна. Ийм үзэл санаа дэлгэрэхийн хирээр, эзэмшил газаргүй хүмүүс нь овгоо нийтэд ил гаргахгүй болж үүнээс үүдэн эгэл ардууд овоггүй байсан гэх яриа ч байдаг.

Ийнхүү овгийн нэрийн түүх явсаар Мэйжийн хувьсгалтай золгосон бөгөөд цэрэг татлага, татвар зэрэгтэй холбоотойгоор шинэ засгийн газар хүн амын бүртгэл тооллого явуулж, бүх хүнийг овгоо сэргээх тогтоол гаргаснаар олон жил овгоо хэрэглэлгүй мартсан жирийн ард өөртэй нь ямар нэгэн холбоо хамааралтай шинэ овог авч бүртгүүлэх болжээ. Жишээ нь;

*Ц.Онон – МУИС-ийн багш, докторант

тариан талбайд гэр нь байдаг учраас 田中Tanaka (田 ta-талбай 中naka-дотор гэсэн утгатай), уулын бэлд амьдардаг болохоор 山下 Yamashita (山yama-уул 下shita-доор гэсэн утгатай) гэхчлэн шинээр овог авч байжээ. Ийнхүү одоогийн япон хүмүүсийн овог бий болжээ. Япон хүний овгийг дараах долоон бүлэгт хувааж үзэж болно.

1 . Үндсэн овог : Энд эзэн хаанаас хүртсэн овог, эзэн хаантай дүйхүйц цөөн тооны

эртний язгууртны овог, IV-р зуунаас хойш хятад, солонгосоос дүрвэн ирж

суурышсан хүмүүсийн овог .

2 . Газрын оноосон нэрээс үүссэн овог: 千葉Chiba, 大阪 Osaka гэх мэт

3 . Уул тал, гол мөрөн, хот тосгон, ой хээрийн нэрээс үүссэн овог: Япон орон уул

ус ихтэй, тэгш талдаа тариалан эрхэлдэг байсантай холбоотойгоор уул, гол, талбай гэсэн үг орсон овог их байдаг.

4 . Зүг чиг заасан овог: 東 Higashi (зүүн) гэх мэт

5 . Эрхэлдэг ажил мэргэжлийг заасан овог: Жишээ нь нохой малладаг байснаас 犬飼 Inukai-нохой маллагч гэх мэт овог бий болжээ.

6 . Шашин суртахуунтай холбоотой овог: Мэйжийн хувьсгалын дараа, хуварга байсан хүмүүс судар шаштирт байдаг бурхны шашны холбогдолт үгсийг овог болгон авч байжээ.

7 . Ноёд язгууртнаас хүртсэн овог: Тулаан тэмцэлд гавъяа байгуулж эзэн ноёноосоо хүртсэн овог.

Өнөө үед Японд 10-15 мянган овог бий гэж үздэг. Хамгийн түгээмэл овог нь 佐藤 Sato, 鈴木Suzuki бөгөөд мянган япон хүний 16 нь Sato, 14 нь Suzuki овогтой байдаг байна.

Япон хүний овог нэр харьцангуй богино буюу ихэндээ хоёроос гурван ханзны нийлэмжээс бүтдэг бөгөөд 勘解由小路 Kadenokoji, 左衛門三郎 Saemonzaburo гэх мэт овгууд хамгийн урт овогт, 井 I, 尾 O, 紀 Ki, 区 Ku, 瀬 Se, 何 Ga, 田 Ta гэх

мэт овгууд хамгийн богино овогт тооцогддог.

Япон хүний овог нь уламжлагдан ирдэг бол нэрийг нь эцэг эх нь өгдөг. Эрт цагаас хүний нэрэнд нууц увидас болон амь нас нь оршдог гэдэгт итгэн, бусдад жинхэнэ нэрээ мэдэгдэх нь хар хэл ам дагуулдаг гэж үздэг байснаас үүдэн япон хүн аль болох нэрээ нууцалдаг байна. Мөн нэр нь хүний зан ааш, ажил үйлст их нөлөө үзүүлдэг гэж үздэг байснаас, бэлгэдлийг бодон хүүхэддээ "шилдэг", "шалгарсан", "ухаантай", "үзэсгэлэнтэй", "хүчтэй", "уужим саруул", "үнэнч шударга" гэсэн утга бүхий ханз орсон нэр хайрлах нь элбэг. Ихэвчлэн 郎 ro (хүү гэсэн утгатай үг) гэж төгссөн нэр эрэгтэй хүүхдийнх, 子 ko (мөн л хүү гэсэн утгатай үг) гэж төгссөн нэр эмэгтэй хүүхдийн нэр байх нь олон. Гэвч сүүлийн үед дээрх 郎 ro, 子 ko төгсгөлтэй нэрийг хүүхэддээ өгөх нь цөөрсөн бөгөөд япон маягийн эртний нэр өгөх нь элбэг болжээ.

Элдэв саад тотгор, өвчин зовлон, хар хэл амнаас хамгаалан зайлуулах үүднээс шинээр мэндэлсэн хүүхэддээ өвөрмөц нэр өгөх, буруу энгэртэй дээл хувцас өмсүүлэх ёс аль ч оронд байдаг. Хүмүүсийн соёл боловсролын түвшин дээшилж, элдэв өвөрмөц гаж нэр өгөх явдал цөөрсөн гэж байгаа боловч Японы хойд нутагт энэхүү уламжлал байсаар буй аж. Зарим өвөрмөц нэр овгийг дурьдвал 衣袋 Ibukuro(хувцасны уут), 妖怪 Yokai (ад, зэтгэр), 新妻 Niizuma(шинэ эхнэр), 髭 Hige (сахал), 保母 Hobo (асрагч эх), 養父 Yofu (өргөж авсан эцэг) гэх мэт болно.

Японд сүмо бөх барилдах хүн шинэ овог нэр авдаг бөгөөд тэрхүү нэр нь тухайн бөхийн харьяалагддаг дэвжээний шүтээн, өөрийнх нь төрсөн газар нутгийн онцлогтой холбоотой нэр байх нь олонтой. Тухайлбал Японы мэргэжлийн сүмогийн Sadogatake дэвжээний бөхчүүд бүгд 琴欧州 Kotooushu, 琴光喜 Kotomitsuki, 琴乃若 Kotonowaka гэхчлэн oyakata буюу багшийнхаа дээдэлдэг япон үндэсний ятга хөгжмийн нэр орсон нэртэй байдаг бол 琴欧州 Kotooushu (琴koto-хуур, 欧州oushu-европ), 黒海Kokkai (Хар тэнгис), 把瑠都Baruto (Балтийн тэнгис) гэх мэт нэр нь уг бөхийн төрсөн газар оронтой нь холбоотой

байна.

Эцэст нь, нэр хүндээ эрхэмлэдэг япончууд овгоо хэлэхээс бус өөрийн нэрээ хэлдэггүй, бусдын нэрийг, ялангуяа өөрөөс ахмад дээд тушаалын хүний нэрийг хэлэх, андуурах, буруу дуудах нь зохисгүй зүйл хэмээн үзэж аль болох албан тушаалаар нь дууддаг билээ.

Ном зүй

1. Цэвэл.Я, “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб.,1966
2. Чулуунбаатар. Л, Онон. Ц,Япон Монгол өвөрмөц хэлцийн толь” ,Уб., 2009
3. Энхбат Д. “Хүмүүний зохист нэр”, Уб., 2004
4. 広辞苑第四版、岩波書店、1992
5. 名前の読み方辞典、東京堂出版、1990
6. 日本語大辞典第二版、講談社、1995
7. 日本事情、大修館書店、2001
8. 日本人の名前の歴史、新人物往社、1999